



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар Д/184

Хэрлэн сум

Хилийн цэргийн 0287 дугаар ангид
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван наймдугаар хуралдааны 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Хилийн цэргийн 0287 дугаар ангид “Хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд” шаардлагатай 23,500,000 (хорин гурван сая таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ